



210

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Журам, чиглэл батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2013 оны 161 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын 2 дугаар эмнэлгээр үйлчлүүлэх албан тушаалтан, орон нутгийн иргэд, хүн амын жагсаалт, тусlamж, үйлчилгээний чиглэл"-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

а) Гурав дахь хэсгийн 3.7 дахь заалтыг "Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторууд" гэж өөрчлөн найруулсугай.

б) Гурав дахь хэсгийн 3.6 дахь заалтад "...аудиторууд", тав дахь хэсгийн 5.5 дахь заалтад "...шинжлэх ухааны докторууд (Dr.Sc), 5.13 дахь заалтад "...Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба" гэж тус тус нэмсүгэй.

в) Долоо дахь хэсгийн 7.2 дахь заалтад "...тушаалын хавсралтын нэгдэх хэсгийн 1.4-1.29-д болон хоёр дахь хэсэгт заагдсан албан тушаалтнууд, тэдний гэр бүл, 16 хүртэлх насны хүүхэд нь тухайн албан тушаалыг эрхэлж байх үедээ үйлчлүүлнэ." гэж найруулгын өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Н.УДВАЛ